**Ажлын баримт: 3001**

**Аудит хийгдсэн нэгж:**
**НДЕГ болон түүний харьяа байгууллагууд**

# - ДОТООД АУДИТЫН АЖЛЫН ТАЙЛАН -

**Аудитын нэр:** Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

**Хамрах хугацаа:** 2021/01/01-2021/12/31

**2022.02.28**

## 1. ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын 2014 оны 07 дугаар сарын 1-ний өдөр Шилэн дансны тухай хууль батлагдаж хууль хэрэгжиж эхэлсэн.

Энэхүү хуулийн үйлчлэлд Нийгмийн даатгалын сангийн төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ хамаарах буюу Нийгмийн даатгалын ерөнхий газар, харьяа байгууллагууд, нийгмийн даатгалын төв сан, аймаг, дүүргийн нийгмийн даатгалын сангууд хамрагдаж байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газар болон түүний харьяа 33 байгууллага, Нийгмийн даатгалын сангийн 31 салбар эрх, нийт 238 хэрэглэгчээр шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хандан *Төсөв, гүйцэтгэл, Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт, Бусад* гэсэн цэсээр Нийт 21 төрлийн мэдээллийг байршуулан мэдээлж, энэхүү мэдээлэлтэй иргэд чөлөөтэй танилцах боломжийг хангаж ажиллаж байна.

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, Төсвийн тухай хуулийн 16.5.6, Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2, Засгийн газрын 2015 оны 483 дугаар тогтоолоор баталсан "Дотоод аудитын дүрэм", Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/86 дугаар тушаалаар баталсан "Нийгмийн даатгалын байгууллагын дотоод аудитын журам"-ыг үндэслэн Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд аудитыг хийж гүйцэтгэлээ.

## 2. АУДИТЫН ЗОРИЛТ БА ХАМРАХ ХҮРЭЭ

### 2.1 Аудитын зорилт

Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд аудит хийж, илэрсэн зөрчил дутагдлыг арилгах, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулж холбогдох байгууллага, албан тушаалтанд хүргүүлэх, удирдлагыг үнэн зөв мэдээллээр хангахад аудитын зорилго оршино.

Дээрх зорилтын хүрээнд аудитыг дараах чиглэлийн дагуу гүйцэтгэсэн болно. Үүнд:

- Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллага буюу Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн эсэх;
- Хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасан Нийгмийн даатгалын сангийн мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн байршуулж мэдээлсэн эсэх;
- Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох албан тушаалтан шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх;

- Хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгосон эсэх;

## 2.2. Аудитын хамрах хүрээ

Аудитаар 2021 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуусталх хугацааны Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг Нийгмийн даатгалын ерөнхий газар, харьяа байгууллагууд, нийгмийн даатгалын төв сан, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын санг хамруулж шалгасан болно.

## 2.3. Аудитын арга аргачлал

Аудитыг гүйцэтгэхэд хуулийг хэрэгжүүлэгч байгууллагын цахим хуудаст байрлуулсан мэдээллийг харилцах дансны хуулга, хөрөнгө мөнгө зарцуулах тухай шийдвэр буюу А, Б тушаал, батлагдсан төсөв, санхүүгийн тайлан, 2020 оны санхүүгийн тайланд өгсөн аудитын дүгнэлт, сарын мэдээ зэрэгт үндэслэн анхан шатны баримттай тулгах, дүн шинжилгээ хийх, тайлан мэдээ, холбогдох албан тушаалтнуудтай уулзалт, ярилцлага зохион байгуулах зэрэг аудитын арга зүйг ашиглаж, аудитын хөтөлбөр, горимын дагуу нотлох баримт цуглуулах арга замаар хэрэгжүүллээ.

Аудитад дараах хууль, журам, тогтоолыг шалгуур үзүүлэлт болгон ашигласан. Үүнд:

- Монгол Улсын 2021 оны Төсвийн тухай хууль;
- Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль;
- Төсвийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам";
- Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор баталсан "Бодлогын баримт бичгийн хэрэгжилт болон захиргааны байгууллагын үйл ажиллагаанд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийх нийтлэг журам";
- Бусад холбогдох хууль, дүрэм, журам

Аудитын үр дүнг тооцоход хангалттай бөгөөд хүрэлцээтэй нотлох баримт цуглуулсан бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга, Хяналт шалгалт хийж гүйцэтгэсэн байцаагч нараар гарын үсэг зуруулж албажуулсан болно.

Аудитад хуудас ажлын баримтыг хавсаргав.

## 3. АУДИТЫН ҮР ДҮН

Дээрх хууль, журам, тогтоолыг аудитын шалгуур үзүүлэлт болгон авч үзье.

**Шалгуур 1. *"Хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1-т заасан байгууллага буюу Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагууд шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх"*** *асуудлын хүрээнд*:

***Аудитаар илэрсэн асуудал:*** Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-т заасан мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, зарим мэдээллийг мэдээлээгүй байна.

***Бодит нөхцөл байдал*:** Нийгмийн даатгалын ерөнхий газар болон түүний харьяа 32 байгууллага нь шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хамрагдаж "... Нийгмийн даатгалын хэлтэс" гэсэн нийтлэг нэртэйгээр үндсэн 34 эрх 155 хэрэглэгчээр shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг байршуулж ажиллаж байна.

Нийгмийн даатгалын байгууллага нь хуулийн дагуу жилд 20 төрлийн мэдээллийг тухай бүр, сар бүр, улирал бүр, хагас жилээр, бүтэн жилээр гэсэн давтамжтайгаар нийт 149 удаа мэдээлэх шаардлагатай байдаг.

Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын байгууллагын мэдээлэл байршуулалт /2021 оны байдлаар/

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 149 | 129 | 20 | 0 | 18,496.97 | 144 | - | 0 | 100.00% | 88.09% |
| 2 | Мэдээллийн технологийн төв | 149 | 147 | 2 | 0 | 4,881.39- | 9 | - | 0 | 100.00% | 98.91% |
| 3 | Нийслэлийн нийгмийн даатгалын газар | 149 | 141 | 7 | 1 | 3,279.03 | 56 | 515.07 | 1 | 99.32% | 95.19% |
| 4 | Багануур дүүргийн НДХ | 149 | 127 | 0 | 22 | 16,652.09 | 74 | 442.50 | 30 | 82.94% | 82.94% |
| 5 | Багахангай дүүргийн НДХ | 149 | 145 | 4 | 0 | 2,799.23 | 13 | - | 0 | 100.00% | 96.93% |
| 6 | Баянгол дүүргийн НДХ | 149 | 138 | 11 | 0 | 108,499.41 | 151 | - | 0 | 100.00% | 92.53% |
| 7 | Баянзүрх дүүргийн НДХ | 149 | 122 | 20 | 7 | 136,838.87 | 17 | 20.89 | 12 | 96.17% | 81.87% |
| 8 | Налайх дүүргийн НДХ | 149 | 136 | 7 | 6 | 17,865.71 | 69 | 38.88 | 13 | 96.45% | 92.49% |
| 9 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 149 | 135 | 0 | 14 | 112,429.08 | 98 | 420.92 | 33 | 90.76% | 90.76% |
| 10 | Сүхбаатар дүүргийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 77,364.73 | 33 | 989.54 | 2 | 98.64% | 83.45% |
| 11 | Хан-Уул дүүргийн НДХ | 149 | 136 | 8 | 5 | 79,798.94 | 56 | 4.29 | 14 | 97.27% | 92.01% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 12 | Чингэлтэй дүүргийн НДХ | 149 | 131 | 7 | 11 | 75,472.23 | 87 | 87.81 | 28 | 93.99% | 88.88% |
| 13 | Архангай аймгийн НДХ | 149 | 148 | 0 | 1 | 37,814.82 | 91 | 32.81 | 2 | 99.45% | 99.45% |
| 14 | Баян-Өлгий аймгийн НДХ | 149 | 135 | 6 | 8 | 36,386.14 | 97 | 120.46 | 59 | 95.63% | 91.51% |
| 15 | Баянхонгор аймгийн НДХ | 149 | 115 | 16 | 18 | 34,063.08 | 92 | 100.88 | 33 | 86.06% | 75.59% |
| 16 | Булган аймгийн НДХ | 149 | 137 | 0 | 12 | 29,427.44 | 70 | 669.52 | 26 | 90.09% | 90.09% |
| 17 | Говь-Алтай аймгийн НДХ | 149 | 135 | 11 | 3 | 25,176.28 | 92 | 797.86 | 16 | 97.96% | 90.62% |
| 18 | Говьсүмбэр аймгийн НДХ | 149 | 135 | 1 | 13 | 8,766.85 | 61 | 588.98 | 31 | 90.60% | 89.92% |
| 19 | Дархан-Уул аймгийн НДХ | 149 | 115 | 14 | 20 | 49,106.71 | 79 | 822.03 | 39 | 84.66% | 75.54% |
| 20 | Дорноговь аймгийн НДХ | 149 | 129 | 20 | 0 | 30,058.33 | 94 | - | 0 | 100.00% | 86.89% |
| 21 | Дорнод аймгийн НДХ | 149 | 135 | 4 | 10 | 36,684.41 | 69 | 176.44 | 9 | 91.94% | 89.00% |
| 22 | Дундговь аймгийн НДХ | 149 | 115 | 3 | 31 | 23,009.62 | 71 | 645.73 | 33 | 78.55% | 76.64% |
| 23 | Завхан аймгийн НДХ | 149 | 112 | 21 | 16 | 33,045.35 | 65 | 897.19 | 14 | 89.29% | 75.69% |
| 24 | Орхон аймгийн НДХ | 149 | 142 | 3 | 4 | 57,638.04 | 65 | 50.49 | 14 | 97.81% | 95.42% |
| 25 | Өвөрхангай аймгийн НДХ | 149 | 131 | 0 | 18 | 46,867.68 | 67 | 865.99 | 41 | 86.95% | 86.95% |
| 26 | Өмнөговь аймгийн НДХ | 149 | 123 | 16 | 10 | 26,109.39 | 81 | 656.18 | 44 | 91.63% | 80.98% |
| 27 | Сүхбаатар аймгийн НДХ | 149 | 135 | 3 | 11 | 23,821.55 | 66 | 580.70 | 22 | 91.91% | 89.52% |
| 28 | Сэлэнгэ аймгийн НДХ | 149 | 132 | 15 | 2 | 5,179.87 | 64 | 30.65 | 8 | 98.64% | 88.72% |
| 29 | Төв аймгийн НДХ | 149 | 128 | 21 | 0 | 42,744.37 | 110 | - | 0 | 100.00% | 85.99% |
| 30 | Увс аймгийн НДХ | 149 | 131 | 10 | 8 | 35,115.69 | 78 | 35.23 | 9 | 93.16% | 86.68% |
| 31 | Ховд аймгийн НДХ | 149 | 107 | 42 | 0 | 34,500.16 | 38 | - | 0 | 100.00% | 72.49% |
| 32 | Хөвсгөл аймгийн НДХ | 149 | 124 | 23 | 2 | 52,689.17 | 15 | 0.39 | 10 | 98.91% | 82.32% |
| 33 | Хэнтий аймгийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 40,760.42 | 62 | - | 1 | 98.64% | 81.32% |
| 34 | Солонгос улс дахь НД-ын тасаг | 149 | 122 | 0 | 27 | 3,074.28 | 205 | 776.70 | 21 | 84.67% | 84.67% |
| Аймгийн дүн | | 3129 | 2687 | 253 | 189 | 708,965.37 | 1527 | 7,071.51 | 411 | 93.42% | 85.30% |
| Дүүргийн дүн | | 1341 | 1193 | 81 | 67 | 627,720.29 | 598 | 2,004.83 | 132 | 95.14% | 89.10% |
| **НИЙТ ДҮН** | | **5066** | **4419** | **363** | **284** | **1,366,417.33** | **2539** | **10,368.11** | **566** | **94.18%** | **87.06%** |

*Тайлбар: Дээрх тоон мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хэрэглэгчийн зүгээс гадна харагдах мэдээллийн байдлаар гаргаагүй бөгөөд холбогдох баримт, тоон мэдээллийг үндэслэн шилэн дансны мэдээлэлд мэдээлэх мэдээллийг үнэн зөв, бүрэн байршуулсан дүнгээр авсан болно.*

Тус аудитаар Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын 2021 онд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээлэл дараах байдалтай байна.

- **Нийт 34 хэрэглэгчээс 5066 мэдээлэл мэдээлэхээс 4419 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, мэдээлэл байршуулалт** 94,18 хувь; Үүнээс:
  *-Аймгийн дундаж:* 93,42 хувь;

*-Дүүргийн дундаж:* 95,14 хувь;

Нийт мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргүүдээр харуулбал:

✓ 100 хувь мэдээлэл байршуулсан:

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, Багахангай, Баянгол дүүрэг, Дорноговь, Төв, Ховд аймгийн нийгмийн даатгалын хэлтэс;

✓ 90,09-99,45 хувиар мэдээлэл байршуулсан:

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Булган аймгийн НДХ | 149 | 137 | 0 | 12 | 29,427.44 | 70 | 669.52 | 26 | 90.09% | 90.09% |
| 2 | Говьсүмбэр аймгийн НДХ | 149 | 135 | 1 | 13 | 8,766.85 | 61 | 588.98 | 31 | 90.60% | 89.92% |
| 3 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 149 | 135 | 0 | 14 | 112,429.08 | 98 | 420.92 | 33 | 90.76% | 90.76% |
| 4 | Өмнөговь аймгийн НДХ | 149 | 123 | 16 | 10 | 26,109.39 | 81 | 656.18 | 44 | 91.63% | 80.98% |
| 5 | Сүхбаатар аймгийн НДХ | 149 | 135 | 3 | 11 | 23,821.55 | 66 | 580.70 | 22 | 91.91% | 89.52% |
| 6 | Дорнод аймгийн НДХ | 149 | 135 | 4 | 10 | 36,684.41 | 69 | 176.44 | 9 | 91.94% | 89.00% |
| 7 | Увс аймгийн НДХ | 149 | 131 | 10 | 8 | 35,115.69 | 78 | 35.23 | 9 | 93.16% | 86.68% |
| 8 | Чингэлтэй дүүргийн НДХ | 149 | 131 | 7 | 11 | 75,472.23 | 87 | 87.81 | 28 | 93.99% | 88.88% |
| 9 | Баян-Өлгий аймгийн НДХ | 149 | 135 | 6 | 8 | 36,386.14 | 97 | 120.46 | 59 | 95.63% | 91.51% |
| 10 | Баянзүрх дүүргийн НДХ | 149 | 122 | 20 | 7 | 136,838.87 | 17 | 20.89 | 12 | 96.17% | 81.87% |
| 11 | Налайх дүүргийн НДХ | 149 | 136 | 7 | 6 | 17,865.71 | 69 | 38.88 | 13 | 96.45% | 92.49% |
| 12 | Хан-Уул дүүргийн НДХ | 149 | 136 | 8 | 5 | 79,798.94 | 56 | 4.29 | 14 | 97.27% | 92.01% |
| 13 | Орхон аймгийн НДХ | 149 | 142 | 3 | 4 | 57,638.04 | 65 | 50.49 | 14 | 97.81% | 95.42% |
| 14 | Говь-Алтай аймгийн НДХ | 149 | 135 | 11 | 3 | 25,176.28 | 92 | 797.86 | 16 | 97.98% | 90.62% |
| 15 | Сүхбаатар дүүргийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 77,364.73 | 33 | 989.54 | 2 | 98.64% | 83.45% |
| 16 | Сэлэнгэ аймгийн НДХ | 149 | 132 | 15 | 2 | 5,179.87 | 64 | 30.65 | 8 | 98.64% | 88.72% |
| 17 | Хэнтий аймгийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 40,760.42 | 62 | - | 1 | 98.64% | 81.32% |
| 18 | Хөвсгөл аймгийн НДХ | 149 | 124 | 23 | 2 | 52,689.17 | 15 | 0.39 | 10 | 98.91% | 82.32% |
| 19 | Нийслэлийн нийгмийн даатгалын газар | 149 | 141 | 7 | 1 | 3,279.03 | 56 | 515.07 | 1 | 99.32% | 95.19% |
| 20 | Архангай аймгийн НДХ | 149 | 148 | 0 | 1 | 37,814.82 | 91 | 32.81 | 2 | 99.45% | 99.45% |
| | **НИЙТ ДҮН** | **2980** | **2659** | **189** | **132** | **918,618.65** | **1327** | **5,817.10** | **354** | **95.45%** | **89.01%** |

✓ 78,55-89,29 хувиар мэдээлэл байршуулсан:

Завхан 89,29 хувь, Өвөрхангай 86,95 хувь, Баянхонгор 86,06 хувь, Солонгос улс дахь Нийгмийн даатгалын тасаг 84,67 хувь, Дархан-Уул 84,66 хувь, Багануур 82,94 хувь, Дундговь 78,55 хувь;

- **Хугацаанд нь мэдээлээгүй, хугацаа хоцроосон 363 мэдээлэл ба нийт мэдээллийн** 7,17 хувь;
  - *-Аймгийн дундаж*: 8,09 хувь;
  - *-Дүүргийн дундаж*: 6,04 хувь;

Хугацаа хоцроосон мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргүүдээр харуулбал:

✓ *Хугацаа хоцроож байршуулсан мэдээлэл байхгүй боловч мэдээлэл байршуулаагүй:*

Архангай, Булган, Өвөрхангай аймаг, Багануур, Сонгинохайрхан дүүрэг, Солонгос улс дахь Нийгмийн даатгалын тасаг;

✓ *0,67-9,40 хувиар мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан:*

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлэвэл зохих | | Үнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Говьсүмбэр аймгийн НДХ | 149 | 135 | 1 | 13 | 8,766.85 | 61 | 588.98 | 31 | 90.60% | 0.67% |
| 2 | Мэдээллийн технологийн төв | 149 | 147 | 2 | 0 | 4,881.39 | 9 | - | 0 | 100.00% | 1.34% |
| 3 | Дундговь аймгийн НДХ | 149 | 115 | 3 | 31 | 23,009.62 | 71 | 645.73 | 33 | 78.55% | 2.01% |
| 4 | Сүхбаатар аймгийн НДХ | 149 | 135 | 3 | 11 | 23,821.55 | 66 | 580.70 | 22 | 91.91% | 2.01% |
| 5 | Орхон аймгийн НДХ | 149 | 142 | 3 | 4 | 57,638.04 | 65 | 50.49 | 14 | 97.81% | 2.01% |
| 6 | Дорнод аймгийн НДХ | 149 | 135 | 4 | 10 | 36,684.41 | 69 | 176.44 | 9 | 91.94% | 2.68% |
| 7 | Багахангай дүүргийн НДХ | 149 | 145 | 4 | 0 | 2,799.23 | 13 | - | 0 | 100.00% | 2.68% |
| 8 | Баян-Өлгий аймгийн НДХ | 149 | 135 | 6 | 8 | 36,386.14 | 97 | 120.46 | 59 | 95.63% | 4.03% |
| 9 | Чингэлтэй дүүргийн НДХ | 149 | 131 | 7 | 11 | 75,472.23 | 87 | 87.81 | 28 | 93.99% | 4.70% |
| 10 | Налайх дүүргийн НДХ | 149 | 136 | 7 | 6 | 17,865.71 | 69 | 38.88 | 13 | 96.45% | 4.70% |
| 11 | Нийслэлийн нийгмийн даатгалын газар | 149 | 141 | 7 | 1 | 3,279.03 | 56 | 515.07 | 1 | 99.32% | 4.70% |
| 12 | Хан-Уул дүүргийн НДХ | 149 | 136 | 8 | 5 | 79,798.94 | 56 | 4.29 | 14 | 97.27% | 5.37% |
| 13 | Увс аймгийн НДХ | 149 | 131 | 10 | 8 | 35,115.69 | 78 | 35.23 | 9 | 93.16% | 6.71% |
| 14 | Говь-Алтай аймгийн НДХ | 149 | 135 | 11 | 3 | 25,176.28 | 92 | 797.86 | 16 | 97.96% | 7.38% |
| 15 | Баянгол дүүргийн НДХ | 149 | 138 | 11 | 0 | 108,499.41 | 151 | - | 0 | 100.00% | 7.38% |
| 16 | Дархан-Уул аймгийн НДХ | 149 | 115 | 14 | 20 | 49,106.71 | 79 | 822.03 | 39 | 84.66% | 9.40% |
| | НИЙТ ДҮН | 2384 | 2152 | 101 | 131 | 588,301.23 | 1119 | 4,463.95 | 288 | 94.33% | 4.24% |

✓ *10,07-28,19 хувиар мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан:*

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Сэлэнгэ аймгийн НДХ | 149 | 132 | 15 | 2 | 5,179.87 | 64 | 30.65 | 8 | 98.64% | 10.07% |
| 2 | Баянхонгор аймгийн НДХ | 149 | 115 | 16 | 18 | 34,063.08 | 92 | 100.88 | 33 | 86.06% | 10.74% |
| 3 | Өмнөговь аймгийн НДХ | 149 | 123 | 16 | 10 | 26,109.39 | 81 | 656.18 | 44 | 91.63% | 10.74% |
| 4 | Баянзүрх дүүргийн НДХ | 149 | 122 | 20 | 7 | 136,838.87 | 17 | 20.89 | 12 | 96.17% | 13.42% |
| 5 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 149 | 129 | 20 | 0 | 18,496.97 | 144 | - | 0 | 100.00% | 13.42% |
| 6 | Дорноговь аймгийн НДХ | 149 | 129 | 20 | 0 | 30,058.33 | 94 | - | 0 | 100.00% | 13.42% |
| 7 | Завхан аймгийн НДХ | 149 | 112 | 21 | 16 | 33,045.35 | 65 | 897.19 | 14 | 89.29% | 14.09% |
| 8 | Төв аймгийн НДХ | 149 | 128 | 21 | 0 | 42,744.37 | 110 | - | 0 | 100.00% | 14.09% |
| 9 | Хөвсгөл аймгийн НДХ | 149 | 124 | 23 | 2 | 52,689.17 | 15 | 0.39 | 10 | 98.91% | 15.44% |
| 10 | Сүхбаатар дүүргийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 77,364.73 | 33 | 989.54 | 2 | 98.64% | 16.11% |
| 11 | Хэнтий аймгийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 40,760.42 | 62 | - | 1 | 98.64% | 16.11% |
| 12 | Ховд аймгийн НДХ | 149 | 107 | 42 | 0 | 34,500.16 | 38 | - | 0 | 100.00% | 28.19% |
| | **НИЙТ ДҮН** | **1788** | **1467** | **262** | **59** | **531,850.71** | **815** | **2,695.71** | **124** | **96.50%** | **14.65%** |

- **Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн 565 шийдвэрийн 10,4 тэрбум төгрөгийн 284 мэдээлэл** байгаа нь нийт мэдээллийн 5,61 хувь;
  - *-Аймгийн дундаж*: 6,04 хувь;
  - *-Дүүргийн дундаж*: 5,00 хувь;

Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн мэдээллийг аймаг, дүүргүүдээр харуулбал:

✓ *Мэдээллийг бүрэн байршуулсан*: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Мэдээллийн технологийн төв, Багахангай, Баянгол дүүрэг, Дорноговь, Төв, Ховд аймаг;

✓ *Нийт байршуулах ёстой мэдээллээс 0,67-9,3 хувь бүхий 1-14 мэдээлэл дутуу байршуулсан:*

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Мэдээлэл байршуулаагүй хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Нийслэлийн нийгмийн даатгалын газар | 149 | 141 | 7 | 1 | 3,279.03 | 56 | 515.07 | 1 | 99.32% | 0.67% |
| 2 | Архангай аймгийн НДХ | 149 | 148 | 0 | 1 | 37,814.82 | 91 | 32.81 | 2 | 99.45% | 0.67% |
| 3 | Сүхбаатар дүүргийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 77,364.73 | 33 | 989.54 | 2 | 98.64% | 1.34% |
| 4 | Сэлэнгэ аймгийн | 149 | 132 | 15 | 2 | 5,179.87 | 64 | 30.65 | 8 | 98.64% | 1.34% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | НДХ | | | | | | | | | | |
| 5 | Хэнтий аймгийн НДХ | 149 | 123 | 24 | 2 | 40,760.42 | 62 | - | 1 | 98.64% | 1.34% |
| 6 | Хөвсгөл аймгийн НДХ | 149 | 124 | 23 | 2 | 52,689.17 | 15 | 0.39 | 10 | 98.91% | 1.34% |
| 7 | Говь-Алтай аймгийн НДХ | 149 | 135 | 11 | 3 | 25,176.28 | 92 | 797.86 | 16 | 97.96% | 2.01% |
| 8 | Орхон аймгийн НДХ | 149 | 142 | 3 | 4 | 57,638.04 | 65 | 50.49 | 14 | 97.81% | 2.68% |
| 9 | Хан-Уул дүүргийн НДХ | 149 | 136 | 8 | 5 | 79,798.94 | 56 | 4.29 | 14 | 97.27% | 3.36% |
| 10 | Налайх дүүргийн НДХ | 149 | 136 | 7 | 6 | 17,865.71 | 69 | 38.88 | 13 | 96.45% | 4.03% |
| 11 | Баянзүрх дүүргийн НДХ | 149 | 122 | 20 | 7 | 136,838.87 | 17 | 20.89 | 12 | 96.17% | 4.70% |
| 12 | Увс аймгийн НДХ | 149 | 131 | 10 | 8 | 35,115.69 | 78 | 35.23 | 9 | 93.16% | 5.37% |
| 13 | Баян-Өлгий аймгийн НДХ | 149 | 135 | 6 | 8 | 36,386.14 | 97 | 120.46 | 59 | 95.63% | 5.37% |
| 14 | Өмнөговь аймгийн НДХ | 149 | 123 | 16 | 10 | 26,109.39 | 81 | 656.18 | 44 | 91.63% | 6.71% |
| 15 | Дорнод аймгийн НДХ | 149 | 135 | 4 | 10 | 36,684.41 | 69 | 176.44 | 9 | 91.94% | 6.71% |
| 16 | Сүхбаатар аймгийн НДХ | 149 | 135 | 3 | 11 | 23,821.55 | 66 | 580.70 | 22 | 91.91% | [illegible] |
| 17 | Чингэлтэй дүүргийн НДХ | 149 | 131 | 7 | 11 | 75,472.23 | 87 | 87.81 | 28 | 93.99% | 7.38% |
| 18 | Булган аймгийн НДХ | 149 | 137 | 0 | 12 | 29,427.44 | 70 | 669.52 | 26 | 90.09% | 8.05% |
| 19 | Говьсүмбэр аймгийн НДХ | 149 | 135 | 1 | 13 | 8,766.85 | 61 | 588.98 | 31 | 90.60% | 8.72% |
| 20 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 149 | 135 | 0 | 14 | 112,429.08 | 98 | 420.92 | 33 | 90.76% | 9.40% |
| | **НИЙТ ДҮН** | **2980** | **2659** | **189** | **132** | **918,618.65** | **1327** | **5,817.10** | **354** | **95.45%** | **4.43%** |

✓ *Нийт байршуулах ёстой мэдээллээс 10,73-20,8 хувь бүхий 16-31 мэдээлэл дутуу байршуулсан:*

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Мэдээлэл байршуулаагүй хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Завхан аймгийн НДХ | 149 | 112 | 21 | 16 | 33,045.35 | 65 | 897.19 | 14 | 89.29% | 10.74% |
| 2 | Баянхонгор аймгийн НДХ | 149 | 115 | 16 | 18 | 34,063.08 | 92 | 100.88 | 33 | 86.06% | 12.08% |
| 3 | Өвөрхангай аймгийн НДХ | 149 | 131 | 0 | 18 | 46,867.68 | 67 | 865.99 | 41 | 86.95% | 12.08% |
| 4 | Дархан-Уул аймгийн НДХ | 149 | 115 | 14 | 20 | 49,106.71 | 79 | 822.03 | 39 | 84.66% | 13.42% |
| 5 | Багануур дүүргийн НДХ | 149 | 127 | 0 | 22 | 16,652.09 | 74 | 442.50 | 30 | 82.94% | 14.77% |
| 6 | Солонгос улс дахь НД-ын тасаг | 149 | 122 | 0 | 27 | 3,074.28 | 205 | 776.70 | 21 | 84.67% | 18.12% |
| 7 | Дундговь аймгийн НДХ | 149 | 115 | 3 | 31 | 23,009.62 | 71 | 645.73 | 33 | 78.55% | 20.81% |
| | **НИЙТ ДҮН** | **1043** | **837** | **54** | **152** | **205,818.81** | **653** | **4,551.02** | **211** | **84.73%** | **14.57%** |

Мэдээлээгүй буюу байршуулаагүй 10,4 тэрбум төгрөгийн 256 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 5,05 хувийг эзэлж байгаагаас:

<u>*Төсөв, гүйцэтгэл*</u> мэдээллийн ангилалд 1666 мэдээлэл байршуулахаас 1027 шийдвэр, гүйлгээний 66 мэдээлэл;

<u>*Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт*</u> мэдээллийн ангилалд 1326 мэдээлэл байршуулахаас 811 шийдвэр, гүйлгээний 111 мэдээлэл;

Бусад мэдээллийн ангилалд 2074 мэдээлэл байршуулахаас 701 шийдвэр, гүйлгээний 79 удаагийн мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлээгүй байна.

Дээрх мэдээлээгүй зөрчлийн дийлэнх хувь нь тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр буюу А, Б тушаалаар мөнгө зарцуулсан байдлыг мэдээлээгүй зөрчил байна.

"Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 6.4-т "Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа санхүүгийн програм, төсвийн төлөвлөлтийн систем, худалдан авах ажиллагааны удирдлагын систем нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зохих маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулах боломжийг хангасан байна" гэж заасан байдаг.

Байгууллагын үйл ажиллагааны програмын сарын мэдээ цэснээс шилэн дансны мэдээллийн маягтын дагуу санхүүгийн мэдээлэл хөрвөх боломж бүрдсэн байгаа нь мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлэх хангалттай боломжтойг харуулж байна.

***Байх ёстой шаардлага:***

- Шилэн дансны тухай хуулийн 3.1.1-д зааснаар төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд буюу байгууллага /Нийгмийн даатгал хэлтэс/ хамрагдаж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа, Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэрийг мэдээлж, хуулийн 4 дүгээр зүйлд зааснаы дагуу мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, нээлттэй байх зарчмыг баримтлахаар заасан.";
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 1.2-т "Төрийн байгууллага... нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй.";
- Журмын 1.3-т "Байгууллага нь мэдээллийг тогтмол шинэчилж, ... нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжийг хангасан байна";
- Журмын 3.2-т "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:";
- Журмын 6.3-т "Шилэн дансны тухай хуулийн 7.1-т заасан дараах албан тушаалтан шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу оруулах үүрэгтэй:";
- Журмын 7.4.3-т "бусад төсөв, санхүүгийн системээс мэдээлэл татсан тохиолдолд тухайн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тавихаас өмнө үнэн зөв эсэхийг сайтар нягтлах";

- Журмын 7.4.4-т "мэдээлэл шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв тавигдсан эсэхийг шалгах.";
- Журмын 7.5.3-т "өөрийн хянах цэсний мэдээллийг байнга хянах.";

***Асуудлын үндсэн шалтгаан:*** Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн мэдээлээгүй, хугацаа хоцроосон, мэдээллийг байршуулахдаа нягтлаагүй, хоосон мэдээлэл байршуулсан байна.

***Үр нөлөө:*** Хэрэглэгчдэд буруу ойлголт төрүүлэх, удирдлага, албан тушаалтан хариуцлага тооцуулах эрсдэлтэй.

***Зөвлөмж:*** Шилэн дансны хуульд заасан мэдээ, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд нь бүрэн байршуулсан байх.

**Шалгуур 2. *"Хуулийн 6 дугаар зүйлийн 6.7-д заасан байгууллага буюу Нийгмийн даатгалын сангийн шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд хамрагдаж, хуульд заасан мэдээллийг хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэх"*** *асуудлын хүрээнд:*

***Аудитаар илэрсэн асуудал:*** Шилэн дансны тухай хуулийн 6.1.2-т заасан мэдээллийг хугацаанд нь байршуулаагүй, мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн байна.

***Бодит нөхцөл байдал:*** Нийгмийн даатгалын сангийн хувьд жилд *төсөв, гүйцэтгэл* мэдээллийн ангилалд 9 төрлийн 49 удаагийн мэдээлэл, *хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт* мэдээллийн ангилалд 5 төрлийн 39 удаагийн мэдээлэл, *бусад* мэдээллийн ангилалд 7 төрлийн 73 удаагийн мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлэх шаардлагатай байдаг.

Шилэн дансны цахим хуудсанд Нийгмийн даатгалын сангийн мэдээлэл байршуулалт /2021 оны байдлаар/

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 161 | 108 | 53 | 0 | 13,230,632.75 | 4788 | 230.00 | 1 | 100.00% | 65.56% |
| 2 | Нийслэлийн нийгмийн даатгалын газар | 12 | 10 | 2 | 0 | 1,182,244.27 | 11 | - | 0 | 100.00% | 83.33% |
| 3 | Багануур дүүргийн НДХ | 161 | 138 | 3 | 20 | 212,097.35 | 441 | 62,944.58 | 20 | 86.39% | 84.56% |
| 4 | Багахангай дүүргийн НДХ | 161 | 151 | 9 | 1 | 47,622.73 | 291 | - | 0 | 99.32% | 93.30% |
| 5 | Баянгол дүүргийн НДХ | 161 | 149 | 12 | 0 | 2,530,519.18 | 12375 | - | 0 | 100.00% | 92.11% |
| 6 | Баянзүрх дүүргийн НДХ | 161 | 105 | 56 | 0 | 2,156,804.48 | 74062 | - | 0 | 100.00% | 64.38% |
| 7 | Налайх дүүргийн НДХ | 161 | 115 | 4 | 42 | 403,967.08 | 1420 | 290,221.21 | 1239 | 69.34% | 66.49% |
| 8 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 161 | 152 | 2 | 7 | 2,171,425.14 | 6339 | 475,884.85 | 7 | 95.24% | 94.10% |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9 | Сүхбаатар дүүргийн НДХ | 161 | 138 | 7 | 16 | 2,953,373.02 | 13802 | 1,593,964.14 | 12051 | 89.79% | 85.17% |
| 10 | Хан-Уул дүүргийн НДХ | 161 | 159 | 2 | 0 | 2,071,939.07 | 10536 | - | 0 | 100.00% | 98.64% |
| 11 | Чингэлтэй дүүргийн НДХ | 161 | 140 | 21 | 0 | 1,406,236.91 | 8098 | - | 0 | 100.00% | 86.36% |
| 12 | Архангай аймгийн НДХ | 161 | 133 | 0 | 28 | 468,329.80 | 909 | 199,075.70 | 608 | 80.95% | 80.95% |
| 13 | Баян-Өлгий аймгийн НДХ | 161 | 150 | 8 | 3 | 592,913.02 | 5571 | 70,234.79 | 3 | 97.96% | 93.86% |
| 14 | Баянхонгор аймгийн НДХ | 161 | 125 | 16 | 20 | 361,689.12 | 1872 | 255,725.39 | 1371 | 86.62% | 76.83% |
| 15 | Булган аймгийн НДХ | 161 | 103 | 28 | 30 | 351,191.23 | 998 | 219,512.53 | 981 | 79.59% | 62.15% |
| 16 | Говь-Алтай аймгийн НДХ | 161 | 158 | 0 | 3 | 422,584.16 | 1829 | 43,169.69 | 3 | 97.96% | 97.96% |
| 17 | Говьсүмбэр аймгийн НДХ | 161 | 110 | 26 | 25 | 115,483.25 | 714 | 60,527.88 | 690 | 85.23% | 69.01% |
| 18 | Дархан-Уул аймгийн НДХ | 161 | 136 | 17 | 8 | 936,258.16 | 3937 | 468,979.92 | 1827 | 94.78% | 83.14% |
| 19 | Дорноговь аймгийн НДХ | 161 | 141 | 20 | 0 | 596,043.33 | 7535 | - | 0 | 100.00% | 86.09% |
| 20 | Дорнод аймгийн НДХ | 161 | 161 | 0 | 0 | 634,428.09 | 4936 | - | 0 | 100.00% | 100.00 % |
| 21 | Дундговь аймгийн НДХ | 161 | 157 | 0 | 4 | 395,190.65 | 4053 | 40,540.52 | 3 | 97.28% | 97.28% |
| 22 | Завхан аймгийн НДХ | 161 | 141 | 10 | 10 | 612,836.12 | 6404 | 298,025.57 | 2565 | 93.20% | 86.94% |
| 23 | Орхон аймгийн НДХ | 161 | 154 | 4 | 3 | 1,177,150.65 | 6289 | 165,594.76 | 3 | 97.96% | 95.11% |
| 24 | Өвөрхангай аймгийн НДХ | 161 | 140 | 1 | 20 | 658,265.17 | 39 | 175,836.47 | 20 | 86.39% | 85.71% |
| 25 | Өмнөговь аймгийн НДХ | 161 | 148 | 5 | 8 | 614,098.49 | 5262 | 95,095.20 | 8 | 94.56% | 91.43% |
| 26 | Сүхбаатар аймгийн НДХ | 161 | 148 | 1 | 12 | 415,872.67 | 3621 | 88,338.32 | 9 | 91.66% | 91.21% |
| 27 | Сэлэнгэ аймгийн НДХ | 161 | 159 | 2 | 0 | 688,798.99 | 3925 | 175,016.38 | 3168 | 100.00% | 98.86% |
| 28 | Төв аймгийн НДХ | 161 | 99 | 49 | 13 | 771,146.53 | 7347 | 312,806.85 | 2332 | 91.25% | 60.25% |
| 29 | Увс аймгийн НДХ | 161 | 154 | 6 | 1 | 521,163.92 | 4851 | 64,107.37 | 1 | 99.32% | 95.51% |
| 30 | Ховд аймгийн НДХ | 161 | 133 | 27 | 1 | 356,768.05 | 65 | - | 0 | 99.32% | 82.54% |
| 31 | Хөвсгөл аймгийн НДХ | 161 | 146 | 12 | 3 | 813,382.84 | 158 | - | 0 | 98.18% | 90.61% |
| 32 | Хэнтий аймгийн НДХ | 161 | 112 | 19 | 30 | 410,660.76 | 26 | - | 0 | 79.59% | 68.55% |
| **Аймгийн дүн** | | 3381 | 2908 | 251 | 222 | 11,914,255.00 | 70341 | 2,732,587.34 | 13592 | 92.94% | 85.43% |
| **Дүүргийн дүн** | | 1449 | 1247 | 116 | 86 | 13,953,986.97 | 127364 | 2,423,014.79 | 13317 | 93.34% | 85.01% |
| **НИЙТ ДҮН** | | **5003** | **4273** | **422** | **308** | **40,281,118.99** | **202504** | **5,155,832.13** | **26910** | **93.50%** | **84.63%** |

*Тайлбар: Дээрх тоон мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд хэрэглэгчийн зүгээс гадна харагдах мэдээллийн байдлаар гаргаагүй бөгөөд холбогдох баримт, тоон мэдээллийг үндэслэн шилэн дансны мэдээлэлд мэдээлэх мэдээллийг үнэн зөв, бүрэн байршуулсан дүнгээр авсан болно.*

Тус аудитаар Нийгмийн даатгалын төв, орон нутгийн байгууллагуудын 2021 онд шилэн дансны цахим хуудсанд байршуулсан нийгмийн даатгалын сангийн мэдээлэл дараах байдалтай байна.

- **Нийт 32 хэрэглэгчээс 5003 мэдээлэл мэдээлэхээс 4273 мэдээллийг хугацаанд нь мэдээлж, мэдээлэл байршуулалт** 93,50 хувь. Үүнээс:

*-Аймгийн дундаж*: 92,94 хувь;
*-Дүүргийн дундаж*: 93,34 хувь;

Нийт мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргүүдээр харуулбал:

✓ 100 хувь мэдээлэл байршуулсан:

Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Баянгол, Баянзүрх, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Дорноговь, Дорнод, Сэлэнгэ аймгийн нийгмийн даатгалын хэлтэс;

✓ 91,25-99,32 хувиар мэдээлэл байршуулсан:

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Төв аймгийн НДХ | 161 | 99 | 49 | 13 | 771,146.53 | 7347 | 312,806.85 | 2332 | 91.25% | 60.25% |
| 2 | Сүхбаатар аймгийн НДХ | 161 | 148 | 1 | 12 | 415,872.67 | 3621 | 88,338.32 | 9 | 91.66% | 91.21% |
| 3 | Завхан аймгийн НДХ | 161 | 141 | 10 | 10 | 612,836.12 | 6404 | 298,025.57 | 2565 | 93.20% | 86.94% |
| 4 | Өмнөговь аймгийн НДХ | 161 | 148 | 5 | 8 | 614,098.49 | 5262 | 95,095.20 | 8 | 94.56% | 91.43% |
| 5 | Дархан-Уул аймгийн НДХ | 161 | 136 | 17 | 8 | 936,258.16 | 3937 | 468,979.92 | 1827 | 94.78% | 83.14% |
| 6 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 161 | 152 | 2 | 7 | 2,171,425.14 | 6339 | 475,884.85 | 7 | 95.24% | 94.10% |
| 7 | Дундговь аймгийн НДХ | 161 | 157 | 0 | 4 | 395,190.65 | 4053 | 40,540.52 | 3 | 97.28% | 97.28% |
| 8 | Баян-Өлгий аймгийн НДХ | 161 | 150 | 8 | 3 | 592,913.02 | 5571 | 70,234.79 | 3 | 97.96% | 93.86% |
| 9 | Говь-Алтай аймгийн НДХ | 161 | 158 | 0 | 3 | 422,584.16 | 1829 | 43,169.69 | 3 | 97.96% | 97.96% |
| 10 | Орхон аймгийн НДХ | 161 | 154 | 4 | 3 | 1,177,150.65 | 6289 | 165,594.76 | 3 | 97.96% | 95.11% |
| 11 | Хөвсгөл аймгийн НДХ | 161 | 146 | 12 | 3 | 813,382.84 | 158 | - | 0 | 98.18% | 90.61% |
| 12 | Багахангай дүүргийн НДХ | 161 | 151 | 9 | 1 | 47,622.73 | 291 | - | 0 | 99.32% | 93.30% |
| 13 | Увс аймгийн НДХ | 161 | 154 | 6 | 1 | 521,163.92 | 4851 | 64,107.37 | 1 | 99.32% | 95.51% |
| 14 | Ховд аймгийн НДХ | 161 | 133 | 27 | 1 | 356,768.05 | 65 | - | 0 | 99.32% | 82.54% |
| | **НИЙТ ДҮН** | **2254** | **2027** | **150** | **77** | **9,848,413.13** | **56017** | **2,122,777.84** | **6761** | **96.29%** | **89.52%** |

✓ 69,34-89,79 хувиар мэдээлэл байршуулсан:

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаандаа мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Налайх | 161 | 115 | 4 | 42 | | 1420 | 290,221.21 | 1239 | 69.34% | 66.49% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүргийн НДХ | | | | | 403,967.08 | | | | | |
| 2 | Булган аймгийн НДХ | 161 | 103 | 28 | 30 | 351,191.23 | 998 | 219,512.53 | 981 | 79.59% | 62.15% |
| 3 | Хэнтий аймгийн НДХ | 161 | 112 | 19 | 30 | 410,660.76 | 26 | - | 0 | 79.59% | 68.55% |
| 4 | Архангай аймгийн НДХ | 161 | 133 | 0 | 28 | 468,329.80 | 909 | 199,075.70 | 608 | 80.95% | 80.95% |
| 5 | Говьсүмбэр аймгийн НДХ | 161 | 110 | 26 | 25 | 115,483.25 | 714 | 60,527.88 | 690 | 85.23% | 69.01% |
| 6 | Багануур дүүргийн НДХ | 161 | 138 | 3 | 20 | 212,097.35 | 441 | 62,944.58 | 20 | 86.39% | 84.58% |
| 7 | Өвөрхангай аймгийн НДХ | 161 | 140 | 1 | 20 | 658,265.17 | 39 | 175,836.47 | 20 | 86.39% | 85.71% |
| 8 | Баянхонгор аймгийн НДХ | 161 | 125 | 16 | 20 | 361,689.12 | 1872 | 255,725.39 | 1371 | 86.62% | 76.83% |
| 9 | Сүхбаатар дүүргийн НДХ | 161 | 138 | 7 | 16 | 2,953,373.02 | 13802 | 1,593,964.14 | 12051 | 89.79% | 85.17% |
| | **НИЙТ ДҮН** | **1449** | **1114** | **104** | **231** | **5,935,056.79** | **20221** | **2,857,807.90** | **16980** | **82.66%** | **75.49%** |

- Хугацаанд нь мэдээлээгүй, хугацаа хоцроосон 422 мэдээлэл ба нийт мэдээллийн 8,43 хувь;
  - *Аймгийн дундаж*: 7,42 хувь;
  - *Дүүргийн дундаж*: 8,01 хувь;

Хугацаа хоцроосон мэдээлэл байршуулалтыг аймаг, дүүргүүдээр харуулбал:

✓ *Хугацаа хоцроож байршуулсан мэдээлэл байхгүй болович мэдээлэл байршуулаагүй:* Архангай, Говь-Алтай, Дундговь;

✓ *0,62-9,94 хувиар мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан:*

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих: Мөнгөн дүн /сая.төг/ | Мэдээлвэл зохих: Шийдвэр, гүйлгээний тоо | Үүнээс: Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Үүнээс: Шийдвэр, гүйлгээний тоо | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Өвөрхангай аймгийн НДХ | 161 | 140 | 1 | 20 | 658,265.17 | 39 | 175,836.47 | 20 | 86.39% | 0.62% |
| 2 | Сүхбаатар аймгийн НДХ | 161 | 148 | 1 | 12 | 415,872.67 | 3621 | 88,338.32 | 9 | 91.66% | 0.62% |
| 3 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 161 | 152 | 2 | 7 | 2,171,425.14 | 6339 | 475,884.85 | 7 | 95.24% | 1.24% |
| 4 | Хан-Уул дүүргийн НДХ | 161 | 159 | 2 | 0 | 2,071,939.07 | 10536 | - | 0 | 100.00% | 1.24% |
| 5 | Сэлэнгэ аймгийн НДХ | 161 | 159 | 2 | 0 | 688,798.99 | 3925 | 175,016.38 | 3168 | 100.00% | 1.24% |
| 6 | Багануур дүүргийн НДХ | 161 | 138 | 3 | 20 | 212,097.35 | 441 | 62,944.58 | 20 | 86.39% | 1.86% |
| 7 | Налайх дүүргийн НДХ | 161 | 115 | 4 | 42 | 403,967.08 | 1420 | 290,221.21 | 1239 | 69.34% | 2.48% |
| 8 | Орхон аймгийн НДХ | 161 | 154 | 4 | 3 | 1,177,150.65 | 6289 | 165,594.76 | 3 | 97.96% | 2.48% |
| 9 | Өмнөговь аймгийн НДХ | 161 | 148 | 5 | 8 | 614,098.49 | 5262 | 95,095.20 | 8 | 94.56% | 3.10% |
| 10 | Увс аймгийн НДХ | 161 | 154 | 6 | 1 | 521,163.92 | 4851 | 64,107.37 | 1 | 99.32% | 3.73% |
| 11 | Сүхбаатар дүүргийн НДХ | 161 | 138 | 7 | 16 | 2,953,373.02 | 13802 | 1,593,964.14 | 12051 | 89.79% | 4.35% |
| 12 | Баян-Өлгий аймгийн НДХ | 161 | 150 | 8 | 3 | 592,913.02 | 5571 | 70,234.79 | 3 | 97.96% | 4.97% |
| 13 | Багахангай | 161 | 151 | 9 | 1 | 47,622.73 | 291 | - | 0 | 99.32% | 5.59% |

| | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | дүүргийн НДХ | | | | | | | | | | |
| 14 | Завхан аймгийн НДХ | 161 | 141 | 10 | 10 | 612,836.12 | 6404 | 298,025.57 | 2565 | 93.20% | 6.21% |
| 15 | Хөвсгөл аймгийн НДХ | 161 | 146 | 12 | 3 | 813,382.84 | 158 | - | 0 | 98.18% | 7.45% |
| 16 | Баянгол дүүргийн НДХ | 161 | 149 | 12 | 0 | 2,530,519.18 | 12375 | - | 0 | 100.00% | 7.45% |
| 17 | Баянхонгор аймгийн НДХ | 161 | 125 | 16 | 20 | 361,689.12 | 1872 | 255,725.39 | 1371 | 86.62% | 9.94% |
| | **НИЙТ ДҮН** | **2737** | **2467** | **104** | **166** | **16,847,114.57** | **83196** | **3,810,989.05** | **20465** | **93.29%** | **3.80%** |

✓ *10,56-34,78 хувиар мэдээлэл хугацаа хоцроож байршуулсан:*

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Хугацаа хоцроож мэдээлэл байршуулсан хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлээгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Дархан-Уул аймгийн НДХ | 161 | 136 | 17 | 8 | 936,258.16 | 3937 | 468,979.92 | 1827 | 94.78% | 10.56% |
| 2 | Хэнтий аймгийн НДХ | 161 | 112 | 19 | 30 | 410,660.76 | 26 | - | 0 | 79.59% | 11.80% |
| 3 | Дорноговь аймгийн НДХ | 161 | 141 | 20 | 0 | 596,043.33 | 7535 | - | 0 | 100.00% | 12.42% |
| 4 | Чингэлтэй дүүргийн НДХ | 161 | 140 | 21 | 0 | 1,406,238.91 | 8098 | - | 0 | 100.00% | 13.04% |
| 5 | Говьсүмбэр аймгийн НДХ | 161 | 110 | 26 | 25 | 115,483.25 | 714 | 60,527.88 | 690 | 85.23% | 16.15% |
| 6 | Нийслэлийн нийгмийн даатгалын газар | 12 | 10 | 2 | 0 | 1,182,244.27 | 11 | - | 0 | 100.00% | 16.67% |
| 7 | Ховд аймгийн НДХ | 161 | 133 | 27 | 1 | 356,768.05 | 65 | - | 0 | 99.32% | 16.77% |
| 8 | Булган аймгийн НДХ | 161 | 103 | 28 | 30 | 351,191.23 | 998 | 219,512.53 | 981 | 79.59% | 17.39% |
| 9 | Төв аймгийн НДХ | 161 | 99 | 49 | 13 | 771,146.53 | 7347 | 312,806.85 | 2332 | 91.25% | 30.43% |
| 10 | Нийгмийн даатгалын ерөнхий газар | 161 | 108 | 53 | 0 | 13,230,632.75 | 4788 | 230.00 | 1 | 100.00% | 32.92% |
| 11 | Баянзүрх дүүргийн НДХ | 161 | 105 | 56 | 0 | 2,156,804.48 | 74062 | - | 0 | 100.00% | 34.78% |
| | **НИЙТ ДҮН** | **1622** | **1197** | **318** | **107** | **21,513,471.72** | **107581** | **1,062,057.17** | **5831** | **93.62%** | **19.36%** |

Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн 26910 шийдвэрийн 5155,83 тэрбум төгрөгийн 308 мэдээлэл байгаа нь нийт мэдээллийн 6,16 хувь;

*-Аймгийн дундаж*: 6,57 хувь;

*-Дүүргийн дундаж*: 5,94 хувь;

Мэдээлээгүй буюу дутуу мэдээлсэн мэдээллийг аймаг, дүүргүүдээр харуулбал:

✓ *Мэдээллийг бүрэн байршуулсан*: Нийгмийн даатгалын ерөнхий газар, Нийслэлийн нийгмийн даатгалын газар, Баянзүрх, Баянгол, Хан-Уул, Чингэлтэй дүүрэг, Дорнод, Сэлэнгэ, Дорноговь аймаг;

✓ *Нийт байршуулах ёстой мэдээллээс 0,62-9,94 хувь бүхий 1-16 мэдээлэл дутуу байршуулсан:*

| № | Байгууллагын | | | | | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|

| | нэр | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлэгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Увс аймгийн НДХ | 161 | 154 | 6 | 1 | 521,163.92 | 4851 | 64,107.37 | 1 | 99.32% | 0.62% |
| 2 | Багахангай дүүргийн НДХ | 161 | 151 | 9 | 1 | 47,622.73 | 291 | - | 0 | 99.32% | 0.62% |
| 3 | Ховд аймгийн НДХ | 161 | 133 | 27 | 1 | 356,768.05 | 65 | - | 0 | 99.32% | 0.62% |
| 4 | Говь-Алтай аймгийн НДХ | 161 | 158 | 0 | 3 | 422,584.16 | 1829 | 43,169.69 | 3 | 97.96% | 1.86% |
| 5 | Орхон аймгийн НДХ | 161 | 154 | 4 | 3 | 1,177,150.65 | 6289 | 165,594.76 | 3 | 97.96% | 1.86% |
| 6 | Баян-Өлгий аймгийн НДХ | 161 | 150 | 8 | 3 | 592,913.02 | 5571 | 70,234.79 | 3 | 97.96% | 1.86% |
| 7 | Хөвсгөл аймгийн НДХ | 161 | 146 | 12 | 3 | 813,382.84 | 158 | - | 0 | 98.18% | 1.86% |
| 8 | Дундговь аймгийн НДХ | 161 | 157 | 0 | 4 | 395,190.65 | 4053 | 40,540.52 | 3 | 97.28% | 2.48% |
| 9 | Сонгинохайрхан дүүргийн НДХ | 161 | 152 | 2 | 7 | 2,171,425.14 | 6339 | 475,884.85 | 7 | 95.24% | 4.35% |
| 10 | Өмнөговь аймгийн НДХ | 161 | 148 | 5 | 8 | 614,098.49 | 5262 | 95,095.20 | 8 | 94.56% | 4.97% |
| 11 | Дархан-Уул аймгийн НДХ | 161 | 136 | 17 | 8 | 936,258.16 | 3937 | 468,979.92 | 1827 | 94.78% | 4.97% |
| 12 | Завхан аймгийн НДХ | 161 | 141 | 10 | 10 | 612,836.12 | 6404 | 298,025.57 | 2565 | 93.20% | 6.21% |
| 13 | Сүхбаатар аймгийн НДХ | 161 | 148 | 1 | 12 | 415,872.67 | 3621 | 88,338.32 | 9 | 91.66% | 7.45% |
| 14 | Төв аймгийн НДХ | 161 | 99 | 49 | 13 | 771,146.53 | 7347 | 312,806.85 | 2332 | 91.25% | 8.07% |
| 15 | Сүхбаатар дүүргийн НДХ | 161 | 138 | 7 | 16 | 2,953,373.02 | 13802 | 1,593,964.14 | 12051 | 89.79% | 9.94% |
| | **НИЙТ ДҮН** | **2415** | **2165** | **157** | **93** | **12,801,786.15** | **69819** | **3,716,741.98** | **18812** | **95.85%** | **3.85%** |

*✓ Нийт байршуулах ёстой мэдээллээс 12,42-26,09 хувь бүхий 20-42 мэдээлэл дутуу байршуулсан:*

| № | Байгууллагын нэр | Нийт мэдээлэх | Хугацаандаа мэдээлсэн | Хугацаа хоцроож мэдээлсэн | Мэдээлэл байршуулаагүй | Мэдээлвэл зохих | | Үүнээс: | | Нийт мэдээлэл байршуулсан хувь | Мэдээлэл байршуулаагүй хувь |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | Мэдээлэгүй мөнгөн дүн /сая.төг/ | Шийдвэр, гүйлгээний тоо | | |
| 1 | Өвөрхангай аймгийн НДХ | 161 | 140 | 1 | 20 | 658,265.17 | 39 | 175,836.47 | 20 | 86.39% | 12.42% |
| 2 | Багануур дүүргийн НДХ | 161 | 138 | 3 | 20 | 212,097.35 | 441 | 62,944.58 | 20 | 86.39% | 12.42% |
| 3 | Баянхонгор аймгийн НДХ | 161 | 125 | 16 | 20 | 361,689.12 | 1872 | 255,725.39 | 1371 | 86.62% | 12.42% |
| 4 | Говьсүмбэр аймгийн НДХ | 161 | 110 | 26 | 25 | 115,483.25 | 714 | 60,527.88 | 690 | 85.23% | 15.53% |
| 5 | Архангай аймгийн НДХ | 161 | 133 | 0 | 28 | 468,329.80 | 909 | 199,075.70 | 608 | 80.95% | 17.39% |
| 6 | Хэнтий аймгийн НДХ | 161 | 112 | 19 | 30 | 410,660.76 | 26 | - | 0 | 79.59% | 18.63% |
| 7 | Булган аймгийн НДХ | 161 | 103 | 28 | 30 | 351,191.23 | 998 | 219,512.53 | 981 | 79.59% | 18.63% |
| 8 | Налайх дүүргийн НДХ | 161 | 115 | 4 | 42 | 403,967.08 | 1420 | 290,221.21 | 1239 | 69.34% | 26.09% |
| | **НИЙТ ДҮН** | **1288** | **976** | **97** | **215** | **2,981,683.77** | **6419** | **1,263,843.76** | **4929** | **81.76%** | **16.59%** |

Мэдээлэлгүй буюу байршуулаагүй 5155,83 тэрбум төгрөгийн 308 мэдээлэл байгаа бөгөөд энэ нь нийт мэдээллийн 6,16 хувийг эзэлж байгаагаас:

*<u>Төсөв гүйцэтгэл</u>* мэдээллийн ангилалд 1519 мэдээлэл байршуулахаас 26897 шийдвэр, гүйлгээний 275 мэдээлэл;

*<u>Хөрөнгө оруулалт, тендер, худалдан авалт</u>* мэдээллийн ангилалд 1209 мэдээлэл байршуулахаас 15 мэдээлэл;

*<u>Бусад</u>* мэдээллийн ангилалд 2275 мэдээлэл байршуулахаас 13 шийдвэр гүйлгээний 18 удаагийн мэдээллийг тогтоосон хугацаанд мэдээлээгүй байна.

Дээрх мэдээлээгүй зөрчлийн дийлэнх хувь нь төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ зэргийг мэдээлээгүй зөрчил байна.

"Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 6.4-т "Байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа санхүүгийн програм, төсвийн төлөвлөлтийн систем, худалдан авах ажиллагааны удирдлагын систем нь шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд зохих маягтын дагуу цахим хэлбэрээр мэдээлэл дамжуулах боломжийг хангасан байна" гэж заасан байдаг.

Нийгмийн даатгалын сангийн сарын мэдээний маягт нь шилэн дансны хуулийн дагуу батлагдсан маягтаас зөрүүтэй байгаа тул мэдээллийг байршуулахдаа маягтыг дарж хуулах, .pdf өргөтгөлөөр оруулах зэрэг боломжийг тэр бүр мэддэггүй байгаа нь хугацаа хоцроох, мэдээлэл байршуулахгүй байхад нөлөөлсөн байна.

***Байх ёстой шаардлага:***

- Шилэн дансны тухай хуулийн 3.2.1-д зааснаар Нийгмийн даатгалын сангийн төсөв хамрагдаж, төсөв, санхүүгийн үйл ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт, тайлагнал эдгээртэй холбоотой мөнгөн болон бусад гүйлгээ, төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах үйл ажиллагаа, Засгийн газар, орон нутгийн баталгаа болон төсвийн өр, авлага үүсгэх аливаа бусад шийдвэрийг мэдээлж, хуулийн 4 дүгээр зүйлд заасны дагуу мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх, мэдээлэл ойлгомжтой, ач холбогдолтой байх, тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх, нээлттэй байх зарчмыг баримтлахаар заасан.";
- Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолын хавсралтаар баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын 1.2-т "Төрийн байгууллага... нь шилэн дансны цахим хуудсанд Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу холбогдох мэдээллийг тавих үүрэгтэй.";
- Журмын 1.3-т "Байгууллага нь мэдээллийг тогтмол шинэчилж, ... нэвтрэх, татаж авах, хэвлэх боломжийг хангасан байна";
- Журмын 3.2-т "Төсвийн байгууллага дараах мэдээллийг дор дурдсаны дагуу тогтоосон хугацаанд нийтэд мэдээлнэ:";
- Журмын 6.3-т "Шилэн дансны тухай хуулийн 7.1-т заасан дараах албан тушаалтан шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу оруулах үүрэгтэй:";

- Журмын 7.4.3-т "бусад төсөв, санхүүгийн системээс мэдээлэл татсан тохиолдолд тухайн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тавихаас өмнө үнэн зөв эсэхийг сайтар нягтлах";
- Журмын 7.4.4-т "мэдээлэл шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв тавигдсан эсэхийг шалгах.";
- Журмын 7.5.3-т "өөрийн хянах цэсний мэдээллийг байнга хянах.";

***Асуудлын үндсэн шалтгаан:*** Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн мэдээлээгүй, хугацаа хоцроосон, хугацаандаа мэдээлсэн хараглавч доторх мэдээлэл хоосон байна.

***Үр нөлөө:*** Хэрэглэгчдэд буруу ойлголт төрүүлэх, удирдлага, албан тушаалтан хариуцлага тооцуулах эрсдэлтэй.

***Зөвлөмж:*** Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд нь бүрэн байршуулсан байх.

**Шалгуур 3. *"Хуулийн 8 дугаар зүйлд заасан холбогдох албан тушаалтан хяналтыг хэрэгжүүлж, өмнөх аудитаар өгсөн албан шаардлага зөвлөмжийг биелүүлсэн эсэх"*** *асуудлын хүрээнд:*

***Аудитаар илэрсэн асуудал:*** Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд Шилэн дансны хуудсанд тавих хяналт сул, аудитаар өгөгдсөн албан шаардлага, зөвлөмжийн биелэлт хангалтгүй байна.

***Бодит нөхцөл байдал*:**

***3.3.1. Шилэн дансны үйл ажиллагаанд тавих хяналтын талаар:*** Шилэн дансны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.2-т "Төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу "төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ" гэж заасны дагуу Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газар хариуцан ажилладаг бөгөөд агентлагийн хэмжээнд шилэн дансны үйл ажиллагаанд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газар чиг үүргийн дагуу дотоод хяналтыг хэрэгжүүлэн ажиллаж байна.

Шилэн дансны тухай хуулийн 7 дугаар зүйлд шилэн дансны мэдээллийг иргэн, олон нийтэд хүргэх үүргийг тухайн зарлага, төлбөрийн даалгаварт нэгдүгээр, хоёрдугаар гарын үсэг зурж гүйлгээ хийсэн албан тушаалтанд хариуцуулсан байна.

Энэхүү үүргийн дагуу Нийгмийн даатгалын ерөнхий газар болон түүний харьяа байгууллагууд Нийгмийн даатгалын байгууллагын 34 эрх, Нийгмийн даатгалын сангийн 31 эрхийн тохируулганд байгууллагын дарга, холбогдох газрын дарга, ахлах нягтлан бодогч нарын мэдээллийг байршуулсан байна.

Аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн системийн админ эрх нь тус бүрийн ахлах нягтлан бодогчид байдаг бөгөөд тухайн админ эрхээр тохиргоо хийх,

улирлын тайлан илгээх, хянах зэрэг шаардлагатай бүх үйлдлийг хийх боломжтой юм.

Агентлагийн нэгдсэн тайлан мэдээ гаргах, хянах админ эрх нь Хөдөлмөр, Нийгмийн хамгааллын яамны Хяналт, шинжилгээ-үнэлгээ, дотоод аудитын газарт байдаг бөгөөд Нийгмийн даатгалын ерөнхий газрын Дотоод аудит, мониторингийн газар нь Засгийн газрын 2016 оны 01 дүгээр сарын 11-ний өдрийн "Журам шинэчлэн батлах тухай" 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох тухай журам"-ын 7.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэн 8.1-т заасан хугацаанд салбарын хэмжээний тайлан мэдээг гар аргаар нэгтгэн хүргүүлж байна.

Шилэн дансны цахим хуудсанд мэдээллийн төрөл тус бүрийн мэдээллийг сангийн нягтлан бодогч, үйл ажиллагааны нягтлан бодогч, хүний нөөцийн мэргэжилтнүүд байршуулан ажиллаж байна.

Аудитын дүнгээр 2021 оны шилэн дансны нийт мэдээлэл байршуулалт 94,12 хувь, мэдээллийг хугацаанд нь байршуулсан байдал 86,32 хувь, мэдээлээгүй 5,88 хувь байгаа нь цаашид Шилэн дансны цахим хуудсанд байршуулсан мэдээллийн үнэн зөв, хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэхэд аймаг, дүүргийн Нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг тогтмол хянаж тавьж ажиллах шаардлагатай байгааг харуулж байна.

### *3.3.2. Шилэн дансны мэдээлэлд хяналт тавих ажилтныг томилж, ажиллуулсан талаар:*

Аудитыг гүйцэтгэх явцад шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл оруулах, хяналт тавьж ажиллах ажилтны судалгааг гаргуулан авч нэгтгэлээ.

Дээрх судалгаагаар хэлтсийн даргын тушаалаар Архангай, Завхан, Увс аймаг, Налайх, Сонгинохайрхан дүүрэг 2016 онд, Дархан-Уул аймаг 2017 онд, Багахангай дүүрэг 2019 онд, Баянхонгор, Төв, Орхон аймаг, Сүхбаатар, Чингэлтэй дүүрэг, Нийслэлийн нийгмийн даатгалын газар 2021 онд, Говьсүмбэр аймаг, Баянгол, Баянзүрх, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс 2022 онд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах болон хяналт тавих ажилтныг тушаалаар томилж ажиллуулсан боловч тушаалаар томилогдсон ажилтнууд албан тушаал өөрчлөгдсөн, ажлаас халагдсан, чөлөөлөгдсөн, тушаалыг шинэчилж албан тушаалтныг томилоогүй зэрэг асуудал нийтлэг байна.

Харин Багануур дүүрэг, Баян-Өлгий, Булган, Говь-Алтай, Дорноговь, Дорнод, Дундговь, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ, Ховд, Хөвсгөл, Хэнтий аймгийн нийгмийн даатгалын хэлтэс шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах, хэрэгжилтэд хяналт тавих албан тушаалтаныг томилоогүй байна.

Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд шилэн дансны цахим хуудсанд мэдээлэл байршуулах, хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг томилоход уг тушаалын хэрэгжилтэд Санхүү бүртгэлийн тасгийн дарга хяналт тавих үүрэгтэйгээр тушаал гаргасан, мөн Хяналт шалгалт, дотоод аудитын тасгийн зүгээс хяналт тавих ажилтныг томилоогүй нь нийтлэг байна.

Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүд нь шилэн дансны цахим хуудсанд нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын сангийн

холбогдох мэдээ, тайлан, мэдээллийг үнэн зөв гаргаж, хуулийн хугацаанд тогтмол хугацаанд байршуулах ажилтан, хуулийн хэрэгжилтэд хяналт тавих ажилтныг хэлтсийн даргын тушаалаар томилж, ажиллуулж биелэлтэд нь хяналт тавих, хэлтсийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгаж, мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэхэд хяналт, шалгалтыг хагас, бүтэн жилээр хийж, үр дүнг тооцож ажиллах шаардлагатай байна.

### *3.3.3. Аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг шилэн дансны мэдээлэл байршуулалтад хяналт шалгалт хийсэн талаар:*

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын баталсан удирдамжийн дагуу аймаг, дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь нийгмийн даатгалын хэлтэс, нийгмийн даатгалын сангийн шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг үнэн зөв, бүрэн байршуулсан эсэхэд хяналт шалгалтыг хийж, нэгтгэл тайлан мэдээг ирүүлсэн байна.

Тус аудитыг Дархан-Уул, Дорноговь, Завхан, Орхон, Увс, Ховд, Хөвсгөл, аймаг, Багануур, Баянгол, Налайх, Сонгинохайрхан, Хан-Уул дүүрэг сайн хийсэн бол, Баян-Өлгий, Говь-Алтай, Говьсүмбэр, Төв, Өвөрхангай, Өмнөговь, Сүхбаатар, Сэлэнгэ аймаг, Багахангай, Баянзүрх, Сүхбаатар дүүрэг хангалттай, Архангай, Баянхонгор, Булган, Дорнод, Дундговь, Хэнтий аймаг, Чингэлтэй дүүрэг чанар муу нэр төдий хийсэн байна.

### *3.3.4. Нийгмийн даатгалын сангийн 2021 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд өгсөн аудитын албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийн талаар:*

Нийгмийн даатгалын сангийн 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд өгсөн аудитын дүгнэлтээр шилэн дансны цахим хуудсанд мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, мэдээллийг зөрүүтэй мэдээлсэн, нөхөн мэдээлсэн, мэдээлээгүй зэрэг зөрчилд Баян-Өлгий, Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг, Багануур, Налайх, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтэс зөвлөмж, Говьсүмбэр аймаг, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсүүдэд албан шаардлагыг хүргүүлсэн байна.

Дээрх зөвлөмж, албан шаардлагын хэрэгжилтийн явцыг аудитын явцад нягтлахад Баянхонгор, Дархан-Уул, Орхон, Өмнөговь, Сэлэнгэ, Хөвсгөл аймаг, Багануур, Налайх, Хан-Уул дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн зөвлөмж, Говьсүмбэр аймаг, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар дүүргийн нийгмийн даатгалын хэлтсийн албан шаардлагын биелэлт хэрэгжээгүй, 2021 онд нийгмийн даатгалын сангийн болон байгууллагын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн, мэдээллийг оруулахдаа хоосон хадгалсан зэрэг зөрчлүүд дахин давтагдсан байна.

Мөн Дотоод аудит, мониторингийн газрын 2019 оны шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн аудитаар төв, орон нутгийн нийгмийн даатгалын байгууллагуудад Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2019 оны "Дотоод

аудитын зөвлөмж хүргүүлэх тухай" 1/1689 дүгээр албан бичиг, 2020 оны "Чиглэл хүргүүлэх тухай" албан бичиг, "Зөвлөмж хүргүүлэх тухай" 1/2006 дугаар албан бичгийг тус тус хүргүүлсэн ба 2021 оны 03 дугаар сард Шилэн дансны тухай хууль, журам, мэдээлэл байршуулахтай холбоотой тулгарч буй бэрхшээл, гарч буй асуудлын талаар нэгтгэсэн ойлголт өгөх зорилгоор Үндэсний аудитын газартай хамтран сургалтыг зохион байгуулж ажилласан боловч аймаг дүүргүүдэд дээрх зөрчил дутагдал гараад байгаа нь зөвлөмжийн биелэлтийг хангалтгүй биелүүлж, ажилдаа хайнга хандаж байгааг харуулж байна.

***Байх ёстой шаардлага:***

- Журмын 6.3-т "Шилэн дансны тухай хуулийн 7.1-т заасан дараах албан тушаалтан шилэн дансны мэдээллийг Шилэн дансны тухай хууль болон энэ журамд заасны дагуу оруулах үүрэгтэй:";
- Журмын 7.4.3-т "бусад төсөв, санхүүгийн системээс мэдээлэл татсан тохиолдолд тухайн мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд тавихаас өмнө үнэн зөв эсэхийг сайтар нягтлах";
- Журмын 7.4.4-т "мэдээлэл шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв тавигдсан эсэхийг шалгах.";
- Журмын 7.5.3-т "өөрийн хянах цэсний мэдээллийг байнга хянах.";

***Асуудлын үндсэн шалтгаан:*** Мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь байршуулахад хяналт тавьж ажиллаагүй байна.

***Үр нөлөө:***

- Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, хугацаанд нь байршуулж байгаа эсэхэд тавих хяналт сул байгаагаас хэрэглэгч бодит мэдээллийг хүссэн цаг хугацаанд нь авч чадахгүй байх.

- Удирдлага, албан тушаалтан хариуцлага тооцуулах эрсдэлтэй.

***Зөвлөмж:***

-Шилэн дансны тухай хуульд заасан мэдээ, мэдээллийг үнэн зөв, хуулийн хугацаанд нь бүрэн байршуулсан эсэхэд хяналт тавьж ажиллах, ажлын үр дүнг тооцох;

-Хяналт тавьж ажиллах ажилтныг шинээр томилон ажиллуулах;

-Хэлтсийн хяналт шалгалтын ажлын төлөвлөгөөнд тусгаж, мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь бүрэн мэдээлсэн эсэхэд хяналт, шалгалтыг хагас, бүтэн жилээр хийж, үр дүнг тооцож ажиллах;

**Шалгуур 4. *"Хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно"*** *асуудлын хүрээнд:*

***Аудитаар илэрсэн асуудал:*** Байгууллага, албан тушаалтны ажлын гүйцэтгэл, үр дүнг дүгнэхдээ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгон ажиллаагүй байна.

***Бодит байдал:*** Төсвийн шууд захирагч нарын 2019-2021 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд Нийгмийн даатгалын байгууллага, нийгмийн даатгалын сангийн

мэдээллийг шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, хугацаанд нь байршуулж байгаа эсэхэд тогтмол хяналт тавьж ажиллах талаар энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгон оруулж, ажлыг дүгнэх, хяналт тавих хөшүүрэг болгож ажиллаагүй байна.

***Байх ёстой шаардлага:***

- Хуулийн 8.2-т “Энэ хуулийн 3.1.1-т заасан төсвийн байгууллага, албан тушаалтны шилэн дансны үйл ажиллагаанд тавих дотоод хяналтыг Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлд заасны дагуу төсвийн ерөнхийлөн захирагч хэрэгжүүлнэ.”
- Хуулийн 8.4-т “Байгууллага, албан тушаалтны ажлын тайланг дүгнэх, дээд шатны байгууллагаас хяналт шалгалт хийхдээ энэ хуулийн хэрэгжилтийг гол үзүүлэлт болгоно.”

***Асуудлын үндсэн шалтгаан:*** Албан тушаалын тодорхойлолтод тусгасан хэдий ч ажил дүгнэх үзүүлтэд оруулаагүй байна.

***Үр нөлөө:*** Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд үнэн зөв, хугацаанд нь байршуулж байгаа эсэхэд тавих хяналт сулрах, мэдээллийг цаг хугацаа хоцроох, мэдээлэхгүй байх, хэрэглэгч үнэн зөв мэдээллийг хүссэн хугацаандаа авч чадахгүй байх эрсдэлтэй.

***Зөвлөмж:*** Төсвийн шууд захирагч нарын гүйцэтгэлийн төлөвлөгөөнд шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зорилт арга хэмжээг тусгах, биелэлтийг тооцож ажиллах;

## 4. ИЛЭРСЭН ЗӨРЧИЛ

Шилэн дансны аудитаар аймаг, дүүргүүдээс ирүүлсэн тайлан мэдээг дахин хянан нягтлахад мэдээллийг хугацаа хоцроож байршуулах, мэдээлээгүй зэрэг зөрчлөөс гадна мэдээлэх ёсгүй мэдээллийг оруулах, хугацаанд нь байршуулсан харагдах боловч доторх мэдээлэл хоосон байх, мэдээллээ байршуулсан хэдий ч Шилэн дансны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.2-т “ Шилэн дансны мэдээлэл татаж авах, хэвлэх боломжтой байх” гэж заасан стандартыг хангаж ажиллаагүй, урьд сарын мэдээллийг дараа сард давтан оруулах, урьд оны мэдээллийг оруулах зэрэг нийтлэг зөрчлүүд илэрсэн. Тухайлбал:

***Архангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Хугацаандаа мэдээлсэн боловч мэдээлэл хангалтгүй. PDF файл байршуулж хэвших.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 12 дугаар сард 2 шийдвэрийн 32,8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Дараа жилийн төсвийн төсөл:* Хугацаанд нь мэдээлсэн боловч байршуулсан файл шаардлага хангахгүй.

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Нийт 18 мэдээ хоосон хадгалсан. Мэдээлэл байхгүй.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 2,3,4,8,9,10,11,12 дугаар сарын мэдээг мэдээлээгүй хоосон хадгалсан.

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Хугацаандаа мэдээлсэн боловч буруу дүнгээр мэдээлсэн.

***Баян-Өлгий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Хугацаандаа мэдээлсэн боловч мэдээлэл хангалтгүй. PDF файл байршуулж хэвших.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 13 шийдвэрийн 34,9 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 45 удаагийн 35,2 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй байна .

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Дараа жилийн төсвийн төсөл:* Хугацаандаа мэдээлсэн боловч байршуулсан файл шаардлага хангахгүй.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 50,3 сая төгрөгийн 2 дугаар сарын үйл ажиллагааны санхүүжилтийг мэдээлээгүй.

***Баянхонгор аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Зарим саруудад буруу оруулсан, тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт шивж оруулсан бөгөөд файлаар оруулаагүй;

✓ *Байгууллагын батлагдсан төсөв*: Нийгмийн даатгалын сангийн батлагдсан төсөв оруулсан;

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 46,1 сая төгрөгийн тэтгэвэрт гарах нэг удаагийн буцалтгүй тэтгэмж, халаалт дулааны зардлын 5,5 сая төгрөгийг мэдээлээгүй;

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 19,6 сая төгрөгийн халаалтын төлбөр, 9,9 сая төгрөгийн шатахууны зардал мэдээлээгүй;

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 9,5 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй, ажилд томилсон тушаалыг оруулсан байна.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 2021 оны 10,11,12 сар, бүтэн жил, 4 дүгээр улирлыг мэдээлээгүй;

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* 4, 9 сард сарын мэдээ оруулсан ба Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/112, А/175 дугаар тушаалаар батлагдсан нэмэлт өөрчлөлтийг оруулаагүй;

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 4,5,6,7,8,9,10 дугаар сарууд хоосон мэдээлэл оруулсан;

✓ *Санхүүгийн тайлан:* Хагас жилд цэсэнд жилийн эцсийн тайлан оруулсан;

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Мэдээллийг гараар шивж оруулсан боловч нийт дүнгээр батлагдсан төсөвт хүрэхгүй, файл хэлбэрээр оруулаагүй, батлагдсан төсвийг 2022 оны 01 дүгээр сарын 13-ны өдөр шивж оруулсан мөнгөн дүн зөрүүтэй байна.

✓ *Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл:* 10-12 дугаар сард 9 сарын мэдээг оруулж тухайн саруудын мэдээллийг оруулаагүй;

***Булган аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56, А/124 дүгээр тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* Халаалтын зардлын 28,6 сая төгрөг 2 сараас хойш, шатахууны зардал 9,5 сая төгрөгийг 10 сараас хойш мэдээлээгүй.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 2 шийдвэрийн 1,5 сая төгрөгийн мэдээллийг тухай бүр мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Дараа жилийн төсвийн төсөл:* Мэдээлээгүй.

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 1-12 дугаар сар болон 4 дүгээр улирал, хагас, бүтэн жилийн хэмнэлт, хэтрэлтийг тухай бүр мэдээлээгүй.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Нийт 12 сарын 963 шийдвэрийн 52,5 тэрбум төгрөгийн орлого, зарлагын мөнгөн гүйлгээг тухай бүр мэдээлээгүй.

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Хугацаа хоцроож мэдээлсэн.

✓ *Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл:* 2 сарын мэдээллийг хугацаа хоцроож мэдээлсэн.

***Говь-Алтай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56, А/124, А/136 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй. 9 дүгээр сард нийгмийн даатгалын санд орсон өөрчлөлтийн А/102 дугаар тушаалыг байршуулсан.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Түлш халаалтын зардал 5,9 сая төгрөг, тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн буцалтгүй тусламжийн 28,1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй.

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Баталгаажуулсан төсөв оруулах.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:*
10,9 сая төгрөгийн шатахууны зардлыг 6 дугаар сард бөөн дүнгээр мэдээлсэн. 31,1 сая төгрөгийн халаалтыг төлбөр мэдээлээгүй.

✓ *Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдээгдэл:* 7 дугаар сард 3 ажилтны ажилд томилох болон ажлаас чөлөөлсөн тушаал оруулсан.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56, А/102, А/136 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Санхүүгийн тайлан:* Нэгдсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан оруулсан.

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Баталгаажсан PDF файл оруулах.

***Говьсүмбэр аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1-12 дугаар сарын үйл ажиллагааны зардлын санхүүжилт, үлдэгдэл төвлөрүүлсэн 285,6 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 1-6,11-12 дугаар сарууды ус дулааны төлбөр болох 23,5 сая төгрөгийн гүйлгээ,

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 3,1 сая төгрөгийн 7 шийдвэрийг мэдээлээгүй.

✓ *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан:* 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан оруулсан байна.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/04, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 677 удаагийн 32243,8 сая төгрөгийн гүйлгээ мэдээлээгүй.

✓ *Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл:* 1, 2 дугаар сар хоосон, 3-11 дүгээр сарын мэдээ ижил тоон дүнтэй.

***Дархан-Уул аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн сарын хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг 2 дугаар хавсралтад заасан маягтын дагуу хийгээгүй, 2021 оны 1, 4, 11 дүгээр сарын мэдээг хугацаа хоцроож байршуулсан;

✓ 2021 оны гүйлгээг сангийн хуваарилалт, төвлөрүүлэлт, санхүүжилт, нийгмийн даатгалын шимтгэлийн орлого, зарлагыг харилцахын програмаас Excel-рүү хөрвүүлэн шүүлт хийж COPY хийж 11 мэдээг хугацаа хоцроож байршуулж 1 мэдээг байршуулаагүй, сар бүрийн төсвийн гүйцэтгэлийн мэдээнд тайлбар оруулаагүй, 11 сард сангийн сарын мэдээг байршуулсан;

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* 2021 оны Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын А/28, А/124, А/175 дугаар тушаалыг байршуулаагүй;

✓ *Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл:* Сангийн яамны санхүүжилтээр "Ухаалаг архивын систем" төслийн 36,1 сая төгрөгийг мэдээлээгүй;

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1-11 дүгээр сарын мөнгөн гүйлгээний дүнг 12 дугаар сард оруулсан боловч оруулвал зохих мэдээллээ оруулаагүй, сангийн мэдээллийг байгууллага дээр оруулсан, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэлийг мэдээлсэн;

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* Гэрэл цахилгааны зардал 5,7 сая, дулааны үнэ 7,3 сая, Хиймэл оюун ухаан автоматжуулалт 36,1 сая төгрөгийг цахим архив төсөлийн худалдан авалтаар мэдээлээгүй;

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 1-11 сарыг 12 сард нөхөж оруулсан боловч 47,2 сая төгрөгийн 7 мэдээллийг оруулаагүй;

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй;

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 1, 4 дүгээр сар хоосон, 11 сард 5,0 сая төгрөгийн мэдээлэл оруулсан;

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Тухайн сарын мэдээллийг дараагийн сард мэдээлсэн, 1822 удаагийн 293865,1 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй, мэдээлэл байршуулсан хэдий ч мэдээлэл татаж авах, хэвлэх боломжийг хангаж ажиллаагүй;

***Дорнод аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 3 дугаар сарын мэдээг гараар шивж оруулсан бөгөөд тоон мэдээллүүд нь буруу, 3 дугаар сараас бусад саруудын мэдээг файл хэлбэрээр байршуулсан боловч гараар шивсэн мэдээллээ засалгүй ижил дүнтэй тоон мэдээлэл давхардаж оруулсан.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 1-5, 10-12 дугаар саруудын дулааны төлбөр 5,0 сая, 1,3,5,10,11,12 дугаар саруудын шатахууны зардал болох 5,5 сая төгрөгийн гүйлгээг тус тус мэдээлээгүй.

***Дундговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1-12 дугаар сарын үйл ажиллагааны санхүүжилт, 11,12 дугаар сарын халаалтын төлбөр, үлдэгдэл төвлөрүүлсэн зэрэг 596,1 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй;

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 1-5, 9-12 дугаар саруудын 30,3 сая төгрөгийн халаалтын төлбөр;

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 19,3 сая төгрөгийн 9 шийдвэрийг мэдээлээгүй;

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй;

***Завхан аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Хэтрэлт хэмнэлтийн тайлбар байхгүй;

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/28, А/92, А/124, А/136 дугаар тушаалаар батлагдсан нэмэлт өөрчлөлтийг мэдээлээгүй;

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1, 2 дугаар сарын мэдээллийг 3 дугаар сард мэдээлсэн, 8, 9 дүгээр сар хоосон, 8, 9 сарын мэдээллийг 10 дугаар сард мэдээлсэн, 24,5 сая төгрөгийн төвлөрүүлэлт, 27,5 сая төгрөгийн өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн тусламж, 10,0 сая төгрөгийн урсгал засвар, түүний санхүүжилт 24,136 сая төгрөгийг мэдээлээгүй;

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 30,5 сая төгрөгийн 3 шийдвэрийг мэдээлээгүй;

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Дараа жилийн төсвийн төсөл:* Үйл ажиллагааны төсөв байршуулсан;

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 1-6 дугаар сар, 9,11 сар, 1 дүгээр улирлын 56,3 сая төгрөгийн 8 мэдээллийг оруулаагүй,

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А102, А/136 дугаар тушаалаар орсон нэмэлт өөрчлөлтийг мэдээлээгүй;

***Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Нийт 13 шийдвэрийн 50,5 сая төгрөгийн мэдээллийг тухай бүр мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 6, 8, 9 дүгээр сарын мэдээг мэдээлээгүй.

***Өвөрхангай аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/136 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* Халаалтын зардлын 21,3 сая төгрөг 3 дугаар сараас хойш, шатахууны төлбөр 10,3 сая төгрөгийг 10 дугаар сараас хойш мэдээлээгүй.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Нийт 9 шийдвэрийн 6,9 сая төгрөгийн мэдээллийг тухай бүр мэдээлээгүй. Мөн 3 шийдвэрийн 33,0 сая төгрөгийг Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 8, 9 дүгээр зүйлд заасан мэдэгдэл цэсэнд байршуулсан.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Нийт 18 мэдээ хадгалсан боловч доторх мэдээлэл байхгүй.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Тухай бүр мэдээлсэн боловч санхүүжилт, төвлөрүүлэлт мэдээлээгүй. Мэдээлэл дутуу оруулсан.

***Өмнөговь аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/124 дүгээр тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* Халаалтын зардал 11,5 сая төгрөгийг 4 дүгээр сараас хойш, цахилгааны төлбөр болох 8,9 сая төгрөгийг 5 дугаар сараас хойш мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 1-3 дугаар улирал, хагас бүтэн жилийн мэдээг хугацаанд нь мэдээлсэн боловч доторх мэдээлэл байхгүй.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

***Сүхбаатар аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Мэдээлээгүй хоосон хадгалсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56, А/124, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* Дулааны зардал 20,6 сая төгрөг, шатахууны зардал 7,4 сая төгрөгийг мэдээлээгүй.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Нийт 3 шийдвэрийн 0,7 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 5, 6, 8 дугаар сар, 3, 4 дүгээр улирал мэдээлээгүй. 7 сараас хойш буруу мэдээ оруулсан.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Мэдээлээгүй хоосон хадгалсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56, А/102, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Мэдээлэх шаардлагагүй дүн мэдээлсэн.

***Сэлэнгэ аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 30,6 сая төгрөгийн 8 шийдвэрийг мэдээлээгүй. Ажилтнуудын ажилд томилогдсон, чөлөөлөгдсөн тушаалуудыг оруулсан.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 3168 удаагийн 175016,3 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй.

***Төв аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Батлагдсан төсвийн гүйцэтгэлийн сарын хэтрэлт хэмнэлтийн шалтгаан, тайлбарыг мэдээ оруулсан боловч тайлбарыг оруулаагүй, 5 дугаар сарын хэтрэлт, хэмнэлтийн шалтгааныг буруу оруулсан, 11 дүгээр сард 10 дугаар сарыг байршуулсан;

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Дараа жилийн төсвийн төсөл:* 2022 оны Нийгмийн даатгалын сангийн төсвийн төслийг байршуулаагүй;

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 12 дугаар сар, 4 дүгээр улирал, бүтэн жилийн мэдээг байршуулаагүй;

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй;

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Тухайн сарын мэдээллийг дараагийн сард мэдээлсэн, 2324 удаагийн 77174,5 сая төгрөгийн орлого, зарлагын гүйлгээг мэдээлээгүй;

✓ *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан:* 2020 оны санхүүгийн тайлангаар өгсөн зөвлөмжийн биелэлтийг байршуулаагүй;

***Увс аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* Хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан бичээгүй;

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* Сумдын шатахууны зардал 5,9 сая төгрөг, дулааны төлбөрийн 29,3 сая төгрөгийг мэдээлээгүй;

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Хөрөнгө мөнгө зарцуулах тухай тушаалыг мэдээлсэн боловч файл хэлбэрээр оруулаагүй, байгууллагын нийгмийн даатгалын шимтгэл, түр орлон гүйцэтгэх, тусгай горимоор ажиллах зэрэг мэдээллийг оруулсан;

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* 7 дугаар сард нөхөж оруулсан байна.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1-11 дүгээр сарын ажил олгогчийн нийгмийн даатгалын шимтгэлийг 12 сард бүрэн оруулж мэдээлсэн;

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* 2021 оны 175 дугаар тушаалаар батлагдсан нэмэлт өөрчлөлтийг мэдээлээгүй, 2021 оны 56, 124 дүгээр тушаалаар төсөвт орсон өөрчлөлтийг 8 сард мэдээлсэн;

***Хөвсгөл аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 388,0 мянган төгрөгийн 2 шийдвэрийг мэдээлээгүй.

***Хэнтий аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Мэдээлээгүй.

✓ *Аудитын тайлан, дүгнэлт, зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний тайлан:* 2020 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан оруулсан байна.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/04 дүгээр тушаалыг 4 дүгээр сард мэдээлсэн. А/102 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 1-12 дугаар сарын мэдээллийг тухай бүр мэдээлээгүй.

***Багануур дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1-12 дугаар сарын үйл ажиллагааны зардлын санхүүжилт 409,6 сая, үлдэгдэл төвлөрүүлсэн 14,2 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй, ажил олгогчийн төлөх нийгмийн даатгалын шимтгэл гэх мэт шаардлагагүй орлого, зарлагын мэдээлэл оруулсан.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 1-12 дугаар сарын түлш халаалтын төлбөр 9,1 сая, аудитын төлбөр болох 7,4 сая төгрөгийн гүйлгээг мэдээлээгүй.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 2,1 сая төгрөгийн 4 шийдвэрийг тус тус мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 3-12 дугаар сар, 1-4 дүгээр улирал, хагас, бүтэн жилийн мэдээлэл хоосон оруулаад хадгалсан.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136, А/175 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Санхүүгийн тайлан:* Хагас жилийн сангийн санхүүгийн тайлан огт оруулаагүй хоосон хадгалсан.

***Баянгол дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136 дугаар тушаалаар тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлтийг мэдээлээгүй;

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1, 2,10-12 дугаар сард мэдээллийг оруулаагүй 12 дугаар сард мэдээлсэн;

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Өмнө мэдээлсэн тушаалыг дахин давтан мэдээлсэн;

***Баянзүрх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* 2, 4 дүгээр сард буруу мэдээлэл оруулсан. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт цэсэнд оруулсан мэдээллийг давхардуулан мэдээлсэн.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 20,8 сая төгрөгийн 12 шийдвэрийг мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 1-12 дугаар сарын мэдээг мэдээлээгүй.

✓ *Санхүүгийн тайлан:* Мэдээлсэн боловч файлыг нээж, татаж авах боломжгүй.

***Налайх дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Төвлөрүүлэлт 13,5 сая, халаалтын зардлын 5,7 сая төгрөгийг мэдээлээгүй;

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө,*

*мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 19,5 сая төгрөгийн 11 шийдвэрийг мэдээлээгүй;

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 195152,2 сая төгрөгийн 1218 ширхэг гүйлгээг бөөн дүнгээр сангаар оруулсан;

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 18 ширхэг 30851,5 сая төгрөгийн мэдээг мэдээлээгүй, зөвхөн санхүүжилтийг мэдээлж зардлыг мэдээлээгүй;

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/175 дугаар тушаалаар баталсан нэмэлт, өөрчлөлтийг мэдээлээгүй;

✓ *Дараа жилийн төсвийн төсөл:* 2021 оны төсвийн төслийг байршуулсан;

***Сонгинохайрхан дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* 1,5,6 дугаар сарын үйл ажиллагааны зардлын санхүүжилт 311,1 сая, 12 дугаар сарын цахилгааны төлбөр 9,4 сая, аудитын төлбөр 6,0 сая, 2 ажилтны тэтгэвэрт гарахад олгох тусламж болох 39,0 сая төгрөгийн гүйлгээг тус тус мэдээлээгүй.

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 11,5 сая төгрөгийн бичиг хэргийн зардлыг мэдээлээгүй.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 43,9 сая төгрөгийн 6 шийдвэрийг тус тус мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт, хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт:* 1,2 дугаар сар, 1 дүгээр улирлын мэдээ хоосон оруулж хадгалсан. 4 дүгээр улиралд буруу тоон мэдээлэл оруулсан.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/04, А/56, А/102, А/136 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг оруулаагүй.

***Сүхбаатар дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Сар бүр мэдээлээгүй хоосон хадгалсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/124, А/136 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Нийт 8 шийдвэрийн мэдээллийг тухай бүр мэдээлээгүй. Бүгд 12 дугаар сард мэдээлэгдсэн.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Сар бүр мэдээлээгүй хоосон хадгалсан. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/102, А/136 дугаар тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

✓ *Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээ:* Сар бүр мэдээлээгүй хоосон хадгалсан ба жилийн эцэст 12 дугаар сард бөөн дүнгээр PDF-файлаар оруулсан.

✓ *Санхүүгийн тайлан:* Мэдээлсэн боловч төсвийн гүйцэтгэлийн нэгтгэсэн тайлан биш гүйлгээ баланс оруулсан.

✓ *Нийгмийн даатгалын сангаас олгосон тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн талаарх мэдээлэл:* 1-3 дугаар сарын мэдээг оруулаагүй. 12 дугаар сарын мэдээг буруу мэдээлсэн.

***Хан-Уул дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* 2 шийдвэрийн 6,2 сая төгрөгийн гүйлгээ хугацаа хоцроож мэдээлсэн.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Нийт 13 шийдвэрийн 4,3 сая төгрөгийн мэдээллийг тухай бүр мэдээлээгүй.

✓ *Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт:* Сар бүр хугацаанд нь мэдээлсэн боловч, албан хаагчийн ангилал тус бүр дэлгэрэнгүй мэдээлээгүй хадгалсан.

***Чингэлтэй дүүргийн Нийгмийн даатгалын хэлтэс:***

*Байгууллага:*

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* 28 шийдвэрийн 87,8 сая төгрөгийн мэдээллийг мэдээлээгүй.

*Нийгмийн даатгалын сан:*

✓ *Байгууллагын батлагдсан төсөв:* Хугацаандаа мэдээлсэн боловч 1 мэдээлэл дутуу оруулсан.

***Нийслэлийн Нийгмийн даатгалын газар:***

*Байгууллага:*

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/124 дүгээр тушаалаар баталсан нэмэлт, өөрчлөлтийг мэдээлээгүй;

***Солонгос улс дахь нийгмийн даатгалын тасаг:***

*Байгууллага:*

✓ *Таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг:* Хэвлэлийн зардал 14,9 сая төгрөгийг 11 сараас хойш мэдээлээгүй.

✓ *Байгууллагын батлагдсан орон тоонд орсон өөрчлөлт:* Сар бүр хоосон хадгалсан. Мэдээлэл оруулаагүй.

✓ *Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр:* Нийт 17 шийдвэрийн 27,7 сая төгрөгийн мэдээллийг тухай бүр мэдээлээгүй.

✓ *Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт, өөрчлөлт:* Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2021 оны А/56, А/124 дүгээр тушаалаар батлагдсан төсөвт орсон нэмэлт өөрчлөлтийг байршуулаагүй.

## 5. НЭГДСЭН ДҮГНЭЛТ

Тус аудитаар Салбарын хэмжээнд 10069 мэдээлэл байршуулахаас нийт мэдээллийн 86,3 хувь буюу 8692 мэдээллийг хугацаанд нь байршуулж, 7,8 хувь буюу 785 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан, 5,9 хувь буюу 592 мэдээллийг мэдээлээгүй байсан бөгөөд хэрэглэгчийн зүгээс харахад мэдээллийг хугацаанд нь мэдээлсэн төлөвт харагдаж байгаа боловч доторх мэдээллийг харахад мэдээлэл байхгүй, мэдээллийг татаж авах боломжоор хангаагүй, урьд сарын мэдээллийг дараа сард давтан оруулах, урьд оны мэдээллийг оруулах зэргээр мэдээллийг үнэн зөв, хугацаанд нь мэдээлээгүй нь Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтэд тавих хяналт сул, цаашид шилэн дансны мэдээллийг хугацаанд нь үнэн зөв, бүрэн байршуулах ажлыг ЭРЧИМЖҮҮЛЭХ шаардлагатай гэж дүгнэлээ.